

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ДОРНОД АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: ДОА-2022/01/НА/СТА-ТЭЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Чойбалсан хот  
2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул  
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn  
Аудитын менежер: И.Сэмжидмаа  
Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn  
Ахлах аудитор: Д.Нармандах  
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**Агуулга**

|  |       |
|--|-------|
| 1. Аудитын санал дүгнэлт .....   | 3     |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....              | 3     |
| 3. Аудитын тайлан.....   | 8     |
| 3.1 Ерөнхий зүйл .....   | 8     |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....                    | 8     |
| 3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал.....                          | 9     |
| 3.4 Материаллаг байдал.....  | 9     |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....                               | 9     |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....                    | 10    |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....               | 12    |
| 3.8 Аудитын гол асуудал.....   | 13    |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.. | 13    |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....                                   | 14    |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....                          | 14    |
| 4. Аудитын илрүүлэлт.....  | 14    |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....                       | 15    |
| 6. Алдаа, зөрчлийн нэгтгэлийн хавсралт.....                            | 16-34 |



**Товчилсон үгийн жагсаалт**

|          |  |
|----------|--|
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт          |
| ДОА      | Дорнод аудитын газар                                   |
| ИТХ      | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал                           |
| ЗДТГ     | Засаг даргын Тамгын газар                              |
| НА       | Нотлох аудит   |
| НДС      | Нийгмийн даатгалын сан                                 |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| ОНХС     | Орон нутгийн хөгжлийн сан                              |
| СХС      | Сум хөгжүүлэх сан                                      |
| СТА      | Санхүүгийн тайлангийн аудит                            |
| ТЕЗ      | Төсвийн ерөнхийлөн захирагч                            |

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р байр  
ЗДТ-ын II байр, Утас/Факс: 7038-4203

2022.04.30 № 453  
танай 2022.04.01 -ны № 1/331 -т

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА,  
М.БАДАМСҮРЭН ТАНАА

#### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

##### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

##### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

##### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020280

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код:  | Тайлангийн үзүүлэлт   | 2020 оны<br>12-р сарын 31 | 2021 оны<br>12-р сарын 31 |
|-------|---|---------------------------|---------------------------|
| 1     | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН   | 23,707,376.7              | 33,171,431.0              |
| 31    | МӨНГӨН ХӨРӨНГӨ  | 9,078,373.8               | 15,892,103.8              |
| 33    | АВЛАГА  | 4,443,308.8               | 5,956,642.1               |
| 34    | УРЬДЧИЛГАА  | 0.0                       | 2,750.0                   |
| 35    | БАРАА МАТЕРИАЛ  | 10,179,194.2              | 11,308,435.1              |
| 36    | НӨӨЦИЙН БАРАА   | 7,500.0                   | 11,500.0                  |
| 2     | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН   | 191,193,491.1             | 206,301,503.3             |
| 39    | ҮНДСЭН ХӨРӨНГӨ  | 191,193,491.1             | 206,301,503.3             |
| 39200 | Биет хөрөнгө  | 174,753,425.2             | 189,754,820.2             |
| 39300 | Биет бус хөрөнгө  | 16,440,065.9              | 16,546,683.2              |
| 3     | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II   | 214,901,867.8             | 239,472,934.3             |
| 4     | НИЙТ ӨР ТӨЛБӨР  | 5,389,675.5               | 5,523,328.6               |
| 41    | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР   | 347,816.5                 | 419,887.9                 |
| 41300 | Өглөг   | 347,816.5                 | 419,887.9                 |
| 42    | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР  | 5,041,859.1               | 5,103,440.7               |
| 42200 | Урт хугацаат зээл   | 5,041,859.1               | 5,103,440.7               |
| 5     | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН  | 209,512,192.2             | 233,949,605.7             |
| 51    | Засгийн газрын хувь оролцоо   | 209,512,192.2             | 233,949,605.7             |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 69,680,920.1              | 71,071,891.2              |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/                                      | 4,050,401.0               | 4,734,223.7               |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн  | 94,947,693.2              | 116,775,208.7             |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 40,833,178.0              | 41,368,282.2              |
| 6     | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V                           | 214,901,867.8             | 239,472,934.3             |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт                                | 2020 оны<br>12-р сарын 31 | 2021 оны<br>12-р сарын 31 |
|------|--|---------------------------|---------------------------|
| I    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                    | 117,697,342.7             | 129,005,012.1             |
| 11   | ТАТВАРЫН ОРЛОГО                                    | 20,303,918.9              | 23,736,544.9              |
| 110  | Орлогын албан татвар                               | 13,338,584.4              | 16,362,452.2              |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар                    | 13,912,980.9              | 16,896,713.8              |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт    | (574,396.6)               | (534,261.7)               |
| 113  | Хөрөнгийн албан татвар                             | 1,084,101.7               | 1,843,839.4               |
| 118  | Бусад татвар, төлбөр, хураамж                      | 5,881,232.9               | 5,530,253.4               |
| 12   | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                | 85,982,552.8              | 91,372,526.3              |
| 120  | Нийтлэг татварын бус орлого                        | 35,057,647.7              | 37,531,822.9              |
| 121  | Хөрөнгийн орлого                                   | 73,811.3                  | 389,606.2                 |
| 122  | Тусламжийн орлого                                  | 3,707,930.0               | 3,930,088.5               |
| 123  | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 47,143,163.8              | 49,521,008.7              |
| 13   | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                      | 11,410,870.9              | 13,897,156.9              |
| II   | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН                        | 81,413,286.2              | 91,283,360.3              |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ                                      | 81,143,286.2              | 91,283,360.3              |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                    | 75,811,138.4              | 85,578,212.6              |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                  | 37,460,879.7              | 41,122,619.8              |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл     | 4,703,511.7               | 5,376,731.1               |

**Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

|            |  |                     |                     |
|------------|--|---------------------|---------------------|
| 2103       | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 2,346,928.4         | 2,575,671.1         |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал                         | 2,136,646.6         | 2,350,789.6         |
| 2105       | Нормативт зардал   | 4,319,992.5         | 5,520,496.3         |
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 683,703.8           | 873,433.9           |
| 2107       | Томилолт, зочны зардал                                   | 170,977.7           | 194,016.8           |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,305,771.2         | 5,923,188.2         |
| 2109       | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 16,682,726.8        | 21,641,265.8        |
| <b>212</b> | <b>ТАТААС</b>  | <b>719,127.5</b>    | <b>725,294.7</b>    |
| <b>213</b> | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                  | <b>4,883,020.3</b>  | <b>4,979,852.9</b>  |
| <b>III</b> | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>             | <b>36,284,056.5</b> | <b>37,721,651.8</b> |
| <b>V</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>                   | <b>25,445,813.9</b> | <b>18,903,498.4</b> |
| <b>VI</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>   | <b>10,818,153.4</b> | <b>18,818,153.4</b> |

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Код: | Тайлангийн үзүүлэлт                             | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|------|---|---|------------------------|
| 1    | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 194,551,212.2                           | 194,551,212.2          |
| 2    | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | 80,382.7                                | 80,382.7               |
| 3    | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 194,631,594.8                           | 194,631,594.8          |
| 4    | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (8,046.1)                               | (8,046.1)              |
| 5    | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                  | 4,050,401.0                             | 4,050,401.0            |
| 6    | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз   | 0.0                                     | 0.0                    |
| 7    | Өмчид гарсан өөрчилөлт                          | 0.0                                     | 0.0                    |
| 8    | Зарласан ногдол ашиг                            | 0.0                                     | 0.0                    |
| 9    | Тайлант үеийн үр дүн                            | 10,838,242.6                            | 10,838,242.6           |
| 10   | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 209,512,192.2                           | 209,512,192.2          |
| 11   | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл             | 209,512,192.2                           | 209,512,192.2          |
| 12   | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | 4,861,856.8                             | 4,861,856.8            |
| 13   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 214,374,049.1                           | 214,374,049.1          |
| 14   | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 74,820.5                                | 74,820.5               |
| 15   | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                  | 682,582.8                               | 682,582.8              |
| 16   | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз   | 0.0                                     | 0.0                    |
| 17   | Өмчид гарсан өөрчилөлт                          | 0.0                                     | 0.0                    |
| 18   | Зарласан ногдол ашиг                            | 0.0                                     | 0.0                    |
| 19   | Тайлант үеийн үр дүн                            | 18,818,153.4                            | 18,818,153.4           |
| 20   | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл           | 233,949,605.7                           | 233,949,605.7          |

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Код:      | Тайлангийн үзүүлэлт                             | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|-----------|---|------------------------|------------------------|
| <b>I</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>   | <b>93,769,974.1</b>    | <b>103,570,042.2</b>   |
| <b>11</b> | <b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>                          | <b>20,303,918.9</b>    | <b>23,736,544.9</b>    |
| 110       | Орлогын албан татвар                            | 13,338,584.4           | 16,362,452.2           |
| 1100      | Хувь хүний орлогын албан татвар                 | 13,912,980.9           | 16,896,713.8           |
| 1101      | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (574,396.6)            | (534,261.7)            |
| 113       | Хөрөнгийн албан татвар                          | 1,084,101.7            | 1,978,078.0            |
| 118       | Бусад татвар, төлбөр, хураамж                   | 5,881,232.9            | 5,396,014.7            |
| 1180      | Бусад нийтлэг төлбөр, хураамж                   | 1,003,814.6            | 693,530.2              |
| 1181      | Газрын төлбөр                                   | 698,200.3              | 1,038,561.0            |
| 1182      | Байгалийн нөөц ашигласны төлбөр                 | 4,179,217.9            | 3,663,923.4            |

**Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

|      |  |                       |                       |
|------|--|-----------------------|-----------------------|
| 12   | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                      | <b>62,004,518.7</b>   | <b>67,619,503.3</b>   |
| 120  | Нийтлэг татварын бус орлого                              | 10,347,681.6          | 13,741,888.4          |
| 121  | Хөрөнгийн орлого   | 73,811.3              | 389,606.2             |
| 122  | Тусламжийн орлого  | 4,439,862.0           | 3,967,000.0           |
| 123  | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг       | 47,143,163.8          | 49,521,008.7          |
| 13   | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                            | <b>11,461,536.5</b>   | <b>12,213,994.0</b>   |
| II   | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | <b>72,364,821.8</b>   | <b>78,368,681.3</b>   |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ  | <b>72,364,821.8</b>   | <b>78,368,681.3</b>   |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | <b>66,762,315.2</b>   | <b>72,685,525.2</b>   |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 38,950,162.6          | 42,640,668.8          |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 5,177,699.1           | 5,907,799.2           |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 2,577,507.1           | 2,995,913.1           |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 2,677,552.6           | 2,973,601.1           |
| 2105 | Нормативт зардал   | 4,295,861.1           | 4,126,848.6           |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 607,499.0             | 864,616.8             |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   | 168,236.7             | 195,189.5             |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,920,066.6           | 4,479,269.5           |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 7,387,730.4           | 8,501,618.7           |
| 212  | ТАТААС   | <b>719,127.5</b>      | <b>725,294.7</b>      |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | <b>4,883,379.1</b>    | <b>4,957,861.4</b>    |
| III  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)      | <b>21,405,152.4</b>   | <b>25,201,360.9</b>   |
| V    | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)                | <b>19,913,880.0</b>   | <b>17,426,744.8</b>   |
| 22   | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   | <b>19,913,880.0</b>   | <b>17,426,744.8</b>   |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр                                      | 19,913,880.0          | 17,426,744.8          |
| VI   | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)    | <b>(19,913,880.0)</b> | <b>(17,426,744.8)</b> |
| VII  | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН   | <b>(561,238.5)</b>    | <b>(960,886.0)</b>    |
| 14   | Бусад эх үүсвэр  | 538.0                 | 114.0                 |
| 23   | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ               | 561,776.5             | 961,000.0             |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)        | <b>930,033.9</b>      | <b>6,813,730.0</b>    |
| 101  | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | 8,148,339.9           | 9,078,339.9           |
| 20   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | 9,078,373.8           | 15,892,103.8          |


**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Код  | Үзүүлэлт   | Төлөвлөгөө          | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|------|--|---------------------|-----------------------------|
| II   | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | <b>84,665,700.9</b> | <b>76,875,207.4</b>         |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ  | <b>65,770,767.5</b> | <b>62,153,664.4</b>         |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | <b>62,137,083.5</b> | <b>59,032,230.9</b>         |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 40,437,841.6        | 39,247,502.4                |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 5,352,026.7         | 5,144,052.8                 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 264,124.7           | 2,422,745.7                 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 1,425,479.1         | 1,384,894.6                 |
| 2105 | Нормативт зардал   | 1,845,565.0         | 1,641,970.2                 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 853,253.2           | 809,201.3                   |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   | 232,731.8           | 173,272.0                   |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,892,117.4         | 1,816,559.0                 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 7,456,761.2         | 6,392,033.2                 |
| 212  | ТАТААС   | <b>725,294.7</b>    | <b>725,294.7</b>            |
| 2121 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас                   | 64,000.0            | 64,000.0                    |
| 2122 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас                | 661,294.7           | 661,294.7                   |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | <b>2,908,389.1</b>  | <b>2,396,138.8</b>          |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг                          | 1,708,822.8         | 1,273,595.0                 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг                                   | 1,199,566.3         | 1,122,543.8                 |

|     |   |              |              |
|-----|---|--------------|--------------|
| 22  | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ                                  | 17,370,438.0 | 13,760,543.0 |
| 23  | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ        | 1,524,495.4  | 961,000.0    |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                    | 84,665,700.9 | 79,353,542.5 |
| 31  | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                           | 40,315,178.6 | 39,616,534.4 |
| 32  | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                    | 33,803,329.3 | 31,688,217.9 |
| 33  | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ      | 315,632.5    | 191,731.4    |
| 35  | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС             | 6,334,560.5  | 3,890,058.8  |
| 36  | ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ                 | 3,897,000.0  | 3,967,000.0  |
| 4   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 0.0          | 2,367,075.5  |
| 5   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0          | 4,800,478.3  |
| 6   | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ                  | 32.9         | 32.7         |
| 61  | БАЙГУУЛЛАГЫН ТОО                                  | 0.2          | 0.2          |
| 62  | АЖИЛЛАГСАДЫН ТОО                                  | 3.8          | 3.7          |
| 63  | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)                | 25.1         | 25.0         |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД         | 18.1         | 18.1         |
| 631 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА          | 7.0          | 6.9          |
| 65  | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ                               | 3.8          | 3.7          |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код  | Үзүүлэлт   | Тайлант оны гүйцэтгэл |
|------|--|-----------------------|
| II   | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | 7,559,936.8           |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ  | 7,514,936.8           |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 5,768,636.3           |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 941,978.8             |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 110,306.7             |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 22,576.4              |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 228,654.6             |
| 2105 | Нормативт зардал   | 1,277,485.9           |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 500,998.3             |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   | 19,882.5              |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 429,080.9             |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 2,237,672.3           |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 1,746,300.5           |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг                                   | 1,686,129.4           |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг                            | 60,171.1              |
| 22   | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   | 45,000.0              |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр                                      | 45,000.0              |
| I    | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                           | 7,570,946.9           |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого                              | 7,570,946.9           |
| III  | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)                 | 11,010.0              |
| 9    | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | 0.0                   |
| 10   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | 11,010.0              |



### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Санхүүгийн тайлангийн аудитыг нийцлийн аудиттай хослуулан хийж АДБОУС 4000.16-д заасны дагуу аудитын дүгнэлтийг тусад нь илэрхийлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагын удирдлагуудад ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгсөн.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитор Б.Одхүү, Б.Оюунхэрлэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 1/771 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээг, Санхүү, хяналт аудитын алба нь төсвийн ерөнхийлөн захирагчийг эрсдэлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба нь аймгийн ОНХС болон 14 сумын 2020 он, 2021 оны 3 дугаар улирлын байдлаарх хөрөнгө оруулалтын төлөвлөлт гүйцэтгэл, худалдан авах ажиллагаанд аудит хийсэн байна. Аудитаар нийт 4,361.5 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 51.8 сая төгрөгийн 16 төлбөрийн акт тогтоон, 1,783.1 сая

төгрөгийн 31 албан шаардлага, 2,526.6 сая төгрөгийн зөрчилд 142 зөвлөмж өгч ажилласан байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь санхүүгийн тайлагналын үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрөхүйц байна гэж тодорхойлсон.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үеийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төлөвлөгөөний нийт зардлын 84,665.7 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 846.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын материаллаг байдлын 70 хувиар буюу 592.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 15,892.1 сая төгрөг болж өмнөх оноос 6,813.7 сая төгрөгөөр өссөн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 13,113.8 сая төгрөг нь төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 11.0 сая төгрөг нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд, 2,763.5 сая төгрөг арилжааны банкны дансанд, 3.8 сая төгрөг касст байршиж байна. Арилжааны банкин дахь хадгаламжийн дансанд Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ нь 500.0 сая төгрөг байршуулан 53.7 сая төгрөгийн хүүгийн орлого бүртгэсэн байна.

Авлага дансны үлдэгдэл 5,956.6 сая төгрөг болж өмнөх оноос 1,513.3 сая төгрөгөөр өссөн шалтгаан нь эрүүл мэндийн даатгалын санхүүжилт дутуу олгогдсонтой холбоотой байна. Авлагын 3.9 сая төгрөг нь ажиллагсадтай холбогдсон, 1,678.5 сая төгрөг нь эрүүл мэндийн даатгалаас, 1.6 сая төгрөг нь дансны авлага, 22.8 сая төгрөг нь зээлийн хүүгийн авлага, 1,703.7 сая төгрөг нь байгууллагаас авах, 2,541.8 сая төгрөг нь хувь хүнээс авах, 4.3 сая төгрөг нь татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн дансны илүү төлөлтийн авлага байна. Нийт авлагын 51.9 хувь буюу 3,090.4 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байна. Үүнээс хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлага нь 1,238.9 сая төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 335.3 сая төгрөгөөр буурсан байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 2.7 сая төгрөг нь тоног төхөөрөмж худалдан авах ажлын төлбөр байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 11,308.4 сая төгрөг болж өмнөх оноос 1,129.2 сая төгрөгөөр өссөн байна. Бараа материалын үлдэгдэл өссөн нь байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай аж ахуйн материалыг худалдан авсантай холбоотой байна. Тайлант онд бараа материал нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 10,101.9 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 896.0 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 643.1 сая, бусад 4,832.8 сая төгрөгөөр нэмэгдэн, балансаас баланст шилжүүлсэн 143.9 сая, зарцуулсан 13,734.1 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 8.4 сая, бусад 1,458.2 сая төгрөгөөр хасагдсан байна. Бараа материалын үлдэгдэлд ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал байхгүй байна.

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 11.5 сая төгрөг болж 4.0 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 206,301.5 сая төгрөг болж өмнөх оноос 15,108.0 сая төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн 91.9 хувийг биет хөрөнгө, 8.1 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна. Тайлант онд үндсэн хөрөнгө нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,016.2 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 7,697.4 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 4,486.1 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 15,729.8 сая төгрөгөөр нэмэгдэн, балансаас баланст шилжүүлсэн 1,897.5 сая, акталсан 3,413.2 сая төгрөгөөр хасагдсан байна. Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 16,546.7 сая төгрөг болж өмнөх оноос 106.6 сая төгрөгөөр өссөн нь бүтцийн өөрчлөлтөөр сум дундын эмнэлэг орон нутгийн төсөвт шилжин ирсэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн үлдэгдэл 5,523.3 сая төгрөг болж өмнөх оноос 133.7 сая төгрөгөөр өссөн байна. Өр төлбөрийн 92.4 хувийг урт хугацаат, 7.6 хувийг богино хугацаат өр төлбөр эзэлж байна. Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл нь Дорнод Нийтийн аж ахуй ОНӨААТҮГ-ын 2005 онд Азийн хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээлийн 4,868.4 сая төгрөгийн өглөг байна. Богино хугацаат өр төлбөрөөс 3.9 сая төгрөг нь ажиллагсадтай холбогдсон, 37.6 сая төгрөг нь бараа үйлчилгээний, 359.4 сая төгрөг нь байгууллагад төлөх, 0.8 сая төгрөг нь хувь хүнд төлөх, 13.7 сая төгрөг нь татварын, 4.4 сая төгрөг нь хөрөнгө бэлтгэхтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 233,949.6 сая төгрөг болж өмнөх оноос 24,437.4 сая төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдэл 41,368.3 сая төгрөг болж өмнөх оноос 535.1 сая төгрөгөөр өссөн нь сум дундын эмнэлэг бүтцийн өөрчлөлтөөр эрүүл мэндийн төв болж орон нутагт нэгтгэгдэн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдэл нь шилжин ирсэнтэй холбоотой байна.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 11,308.9 сая төгрөгөөр буюу 9.6 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 9,875.7 сая төгрөгөөр буюу 12.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бүтцийн өөрчлөлтөөр шилжин ирсэн эрүүл мэндийн төвүүдийн зардлын дүнгээр нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 40,315.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 33,803.3 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 6,334.6 сая төгрөг, тусламжийн эх үүсвэрээс

3,897.0 сая төгрөг, НДС-аас 315.6 сая төгрөг нийт орлогыг 84,665.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж батлуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 3 дугаар хуралдааны 5 дугаар тогтоолоор аймгийн 2021 оны төсөвт төвлөрүүлэх орлогыг 72,129.8 сая төгрөгөөр, Хэрлэн сумын төсвөөс авах татаасыг 437.5 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,430.2 сая төгрөгөөр, аймгийн төсвөөс зарцуулах зарлагыг 19,419.9 сая төгрөгөөр, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга, хөтөлбөр арга хэмжээг 1,873.6 сая төгрөгөөр, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг 8,027.0 сая төгрөгөөр, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх төсөл арга хэмжээг 1,035.5 сая төгрөгөөр, сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 7,420.6 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангаас сумдад олгох шилжүүлгийг 4,508.8 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийг 39,849.8 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Аймгийн 2021 оны төсөвт иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 4 дүгээр, 2021 оны 6/02 дугаар, 2021 оны 6/03 дугаар тогтоолоор 3 удаа өөрчлөлт хийн баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 31,688.2 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 39,616.5 сая төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсвөөс 191.7 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 3,890.1 сая төгрөг, хандив тусламжаас 3,967.0 сая төгрөг, нийт 79,353.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 76,875.2 сая төгрөг буюу 90.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд зааснаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 6/03 дугаар тогтоолоор 18,721.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 21,172.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 113.1 хувиар биелүүлэн байна.


Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 1,258.8 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 5,720.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 423.9 сая төгрөг, хандив, тусламжаас 167.8 сая төгрөг, нийт 7,570.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 1,052.2 сая, байр ашиглах зардалд 22.6 сая, хангамж, бараа материалын зардалд 228.7 сая, норматив зардалд 1,277.5 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 501.0 сая, дотоод албан томилолт 19.9 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 429.1 сая төгрөг, бусад зардалд 2.237.6 сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 508.5 сая төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 559.5 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 618.1 сая төгрөг, хөрөнгийн зардалд 45.0 сая төгрөгийг тус тус зарцуулан, 60.2 сая төгрөгийг төвлөрүүлэн, 11.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.




### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн үр дүнг тусгалаа. Үүнд:

1. Засгийн газрын 2021 оны 42 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд аймгийн хэмжээнд дараах арга хэмжээг авч ажилласан байна.
  - Ковид-19 цар тахалтай холбоотой улсын болон хувийн эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлэхэд 9,910.3 сая, гэрийн хяналтад эмчлүүлэхэд 1,960.0 сая, дархлаажуулалтад 624.2 сая, тандалт, сорьц авахад 832.9 сая, нийт 13,327.4 сая төгрөгийг зарцуулж, дархлаажуулалтын 1-р тунд 55,517, 2-р тунд 53,562, 3-р тунд 24,448 хүнийг тус тус хамруулсан байна. Оны эцэст эрүүл мэндийн байгууллагууд нь ЭМДС-аас авах 5,514.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан тайланд тусгасан байна.
  - Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр “Өрхийн тариалан” хөдөлгөөн өрнүүлж улсын төсвийн 8.4 сая төгрөгийн хөрөнгөөр 11 нэр төрлийн 3.5 тонн хүнсний ногооны үрийг 14 сумдад, 1.0 сая төгрөгийн 700м2 нийлэг хальсан хүлэмжийн хучлагыг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр 5 сумдад захиалгын дагуу нийлүүлэн 2,082.2 тонн төмс, 1,549.8 тонн хүнсний ногоо хураан авсан байна.
2. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах “Наранбулаг хөгжил”, “Гурванзагал хөгжил”, “Сэргэлэн хөгжил”, “Хулстай хөгжил”, “Эрээнцав хөгжил”, ОНӨААТҮГ-ууд тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй, удирдлага нь тодорхойгүй байна. Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Мөн 2021 оны төсвийн бодлогыг хэрэгжүүлэхдээ төрийн өмчийн компаниудын ашигт ажиллагааг нэмэгдүүлж, ил тод байдлыг ханган засаглалыг сайжруулж, орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг тусгажээ. Хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг хариуцдаг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах 12 ОНӨААТҮГ-уудын 41.6 хувь буюу 5 аж ахуйн нэгж тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй байна. Иймд орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн удирдлага, зохион байгуулалт, үр ашгийг дээшлүүлэх бодлого зохицуулалтыг тодорхойлох хууль эрх зүйн нэгдсэн заавар, аргачлал өгч үр дүнг сайжруулах шаардлагатай байна.
3. Аймгийн Төрийн сан болон орон нутгийн Төрийн санд нийт 430 орлогын данс бүртгэлтэй байна. Эдгээр дансанд тайлант онд 657 орлогын гүйлгээний 23,736.5 сая төгрөгийн орлогыг бүртгэн тайланд тусгасан байна.
4. Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяаны байгууллагууд нь 2021 онд орон нутгийн 6 телевиз, 1 радио, 2 сонин, 3 веб сайттай хамтран ажиллах 77.4 сая төгрөгийн 21 гэрээ байгуулан цар тахалтай холбоотой аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдаан, Онцгой комиссоос хэрэгжүүлж буй цаг үеийн ажил зэрэг дунджаар 280 гаруй мэдээллийг түгээн ажилласан байна. Үүнд нийт 76.8 сая төгрөгийг зарцуулан ажилласан байна. ТВ6 телевиз 2021 оны 4 дүгээр сард гэрээний дагуу үүргээ гүйцэтгээгүй тул 0.6 сая төгрөгийг дутуу шилжүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө”, “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-т хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө хөтөлбөр боловсруулаагүй, төлөвлөгөөний хавсралтад заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлийг Засгийн газар, холбогдох яамдаас ирүүлээгүй байна.



### 3.8 Аудитын гол асуудал

- 1.Цагаан-Овоо, Хөлөнбуйр сумын ЗДТГ, Байгаль хамгаалалтын захиргаа, Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-т “хязгаарлалттай” санал дүгнэлт, Хөлөнбуйр сумын Соёлын төв-д “татгалзсан” санал дүгнэлтийг хүргүүлсэн.
- 2.Төсвийн захирагчдын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар ажил олгогчийн буруугаас ажлаас халагдаж шүүхээр шийдвэрлэгдэж шүүхийн шийдвэрээр “Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ нь төсвөөс 1.5 сая төгрөгийг олгосон байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

